

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2023 оны 01 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан

2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Суманд зохион байгуулагдсан түйл ажиллагаа:

"Сүхбаатар аймгийн аварга шалгаруулах АДУУЧИН тэмцээн 2023"-ыг 1 сарын 09-ны өдөр Сүхбаатар аймгийн Адуучдын холбоо, Уулбаян сумын ЗДТГ, Түвшинширээ сумын ЗДТГ-ууд хамтран амжилттай зохион байгууллаа.



Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөөс 20 тн өвс татан 1 өрхөд 5 ширхэг шинэ боодол өвс, 1 боодол өвсийг 10000 төгрөгөөр тооцож, сумын Засаг даргийн цохолт бичгээр иргэд, малчдад 1 сарын 10-ны өдөр олгосон.

Уулбаян сумын харьяат цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицер, ахлагч нарын 2023 оны цэргийн бүртгэл 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл явагдлаа.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойн баярыг тохиолдуулан "ҮНДСЭН ХУУЛИЙГ ХЭН САЙН МЭДЭХ ВЭ?" АХА тэмцээнийг зохион байгууллаа.



2023 оны 01 сарын 25-ны өдөр Сумын Иргэдтэй уулзан мэдээллийн цаг хийж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажиллалаа. Уг мэдээллийн хуралд нийт 60 гаруй иргэд оролцсон.



Өвөлжилт хаваржилтийн бэлтгэл ажлын хүрээнд отроор өвөлжиж буй 26 айлын нийт 78 өрх айлуудаар 2022 оны 01 сарын 24-ны өдрөөс эхлэн Сумын Засаг Дарга болон Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Дарга, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн, Багийн засаг дарга нар тойрч малчдад тулгамдаж буй асуудлыг сонсож шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Газрын чиглэлээр:

2023 оны 01 сарын 11-ны өдөр “Газрын багц хуулийн” танилцуулга хийн хуулийн төсөлд санал авсан нийт 18 албан хаагч оролцсон.



Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2022 оны 05 сарын 01-ээс “Цахим гарын үсгийн тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш 16-аас дээш насны 810 иргэнд тоон гарын үсэг олгосон байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 9411.6 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -132.0 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 6500.0мян төг
- ЭМДаатгалын шимтгэл -2779.6 мян төг орлоо.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох-1 тэтгэврээ өөрчлөн тогтоолгох- өргөдөл-2 , Банк солих-2, тэтгэмж-4, ажилгүйдлын тэтгэмж-0, малчнаар ажилласан жилээ тогтоолгох -0 нийт 9 өргөдлийг хүлээн авч бүрэн шийдвэрлэж. 90 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож, олгох ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж санд мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлж, тэтгэврийн санд 144000.0 сая төгрөгний санхүүжилт, тэтгэмж дээр 0,0 мян төгрөгний санхүүжилт авснаар

- Тэтгэвэрт - 479 тэтгэвэр авагчдад 237043.1 мян төгрөгний тэтгэвэр,
- ХЧТА тэтгэмжинд- 1 даатгуулагчдад 18.0 мянган төгрөг,
- Оршуулгын тэтгэмжинд- 2 тэтгэвэр авагчдад 4000,0 мян төгрөг,
- Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг- 1 даатгуулагчдад 1033.2 мян төг, нийт 242094.3 мян төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгоод олголтын зөрчилгүй ажиллаж байна.

Нийгмийн даатгалд хамрагдаагүй “Рашааны тунгаамал” ХХК-ийг шинээр нийгмийн даатгалд хамруулан 107,8 мян төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлэн авлаа.

Иргэдийн мэдээллийн цагаар Нийгмийн даатгалын хуулинд орсон өөрчлөлтөөр сургалт хийлээ.

Сумын нийгмийн даатгалын сангийн тайланг цахимаар гаргаж нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэв.

2022оны харилцахын-4, тооцооны хуудас тайлан-2, хөнгөлөлт чөлөөлөлтийн тайлан-1 зогсоогдсон 27 тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Хүн ам зүй нийгмийн бодлогын чиглэлээр:

“Алдарт эхийн 1,2 дугаар одон”-ийн болзол хангасан эхчүүдийн материалыг хүлээн авч байна. 2023 оны 01сарын 27ны байдлаар 5 эхийн материалыг хүлээн аваад байна.

Аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас эрсдлийн программд байгаа өндөр эрсдэлтэй 5 хүүхдүүдэд бэлэг хүргүүлсэн. Үүнийг багийн дарга нартай хамтран хүргэж өгөв. Мөн бүтэн өнчин хүүхдүүдэд зузаан хувцасны дэмжлэг үзүүлсэн.

Хүүхдийн тусламж 108-д ирсэн Баян багийн нэг дуудлагыг хүлээн авч багийн даргатай хамтран ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн төслийг хүлээн авч эхэлсэн.

**"ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН"
ЗЭЭЛИЙН ТӨСЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ
ЭХЭЛЛЭЭ**

**ХЭН ХҮСЭЛТ ГАРГАХ
ВЭ?**

**ХОРШОО, ЖИЖИГ ДУНД
ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧ ИРГЭН**

Зээлийн ерөнхий нөхцөл
Зээлийн хугацаа: /36 сар/
Зээлийн хүү /3 хувь/

Төсөл хүлээн авах хугацаа
Эхлэх: 2023 оны 01 сарын 10
Дуусах: 2023 оны 02 сарын 10

Зээл олгох тэргүүлэх чиглэл:

- Ахуй үйлчилгээ
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ
- Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ
- Барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ
- Авто засвар үйлчилгээ
- Хог ангилан ялгалтын үйлчилгээ

**Төсөл хүлээн авах хаяг: Уулбаян сумын ЗДТГ
Холбоо барих утас: 88487253**

**"ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН"
ЗЭЭЛИЙН ТӨСЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ
ЭХЭЛЛЭЭ**

**Төсөл дараах нийтлэг
шалгуурыг хангасан байна**

- СУМАНД ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД ОРОН НУТГИЙН НӨӨЦӨД ТҮШИЙГЛЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ БИЙ БОЛГОХ, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ЧИГЛЭСЭН БАЙХ.
- ТӨСЛИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТ ТОДОРХОЙ БАЙХ.
- ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ЗЭЭЛИЙГ ЭРГЭН ТӨЛӨХ БОЛОМЖТОЙ БАЙХ.
- ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН МӨНГӨН ДУНД ХҮРЭЛЦЭХҮЙЦ БАРЬЦАА ХӨРӨНГӨТӨЙ БАЙХ.
- АЖЛЫН БАЙР НЭМЭГ ДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БАЙХ.

**Зээл авч, төсөл хэрэгжүүлэх
хоршоо ЖДҮҮ эрхлэгч нь дараах
шаардлагыг хангасан байна**

- Тухайн суманд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг байх.
- Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.
- Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх.
- Хөршөөлөх үйл ажиллагаа болон жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх.

**Төсөл хүлээн авах хаяг: Уулбаян сумын ЗДТГ
Холбоо барих утас: 88487253**

Хоршоо хөгжүүлэх санд 2022 онд нийт 108 сая төгрөгний эргэн төлөлт төлөгдсөн.

Мал эмнэлгийн чиглэлээр:

2023 оны 01 сарын 01нээс Мал эмнэлгийн нэгдсэн систем шинэчлэгдсэнтэй холбогдуулан хувийн хэвшлийн мал эмнэлгийн малын эмч нарт цахим мал эмнэлгийн гэрчилгээний шинэчилсэн хувилбараар бичих зааварчилгаа өгч ажилласан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023-01-19-ний өдрийн № 01/85 тоот Чиглэл хүргэх тухай бичгийг хүлээн авч, сумын малын эмч, мал бүхий иргэдэд танилцуулж анхаарал сэрэмжлүүлэг өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 сарын 09-ны өдрийн № 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах зорилгоор сумын Засаг даргын Албан даалгавар гарган гэрийн тэжээвэр амьтдыг гэрчилгээжүүлж, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулахаар ажиллаж байна.